



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар 4/446

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Шинэ Мөрөн хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг хэрэгжүүлэн төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг ханган, төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Улам-Өсөх – Аймгийн Засаг даргын тамгын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Х.Цэнд-Аюуш-Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга

Н.Шинэбаяр- Газрын харилцаа Барилга, Хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Б.Баттөмөр- Хөвсгөл “Дулааны цахилгаан станц” ТӨХК-ын захирал

Г.Даваадорж-Хөвсгөл Эрчим хүч ХХК ерөнхий инженер

Д.Сүхээ- Хөвсгөл Ус суваг ХХК-ын ерөнхий инженер

Б.Бат-Оргил-Аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн
хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ж.Адьяасүрэн-Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Д.Сандагдорж –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

2.Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж холбогдох шийдвэр гарган хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ